

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2019.04.25-2019.05.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Бэлэхийн улаан өндөр”, “Нэртийн цагаан өндөр” овоо тахилгын наадмуудыг 05-р сарын 18, 25-ны өдрүүдэд зохион байгуулж 3 насны морь уралдуулж, 16 хүчит бөх барилдаж шагайн харваачид онч мэргэнээ сорьлоо.



1, 2-р багийн иргэдийн нийтийн хурлыг 2019 оны 05-р сарын 22, 23-нд зохион байгуулж 2019 онд хийгдэж буй ажлыг танилцуулж 2020 оны ОНХС-аар хийгдэх ажлын саналыг эрэмбэлж, цаг үеийн асуудлуудыг хэлэлцсэн. 1-р багийн хуралд 180 ёдәүí , 2-р багийн хуралд 92 иргэн хамрагдаж 100 гаруй гарын авлага, материалыг тарааж ажилласан.



Аймгийн Засаг даргын нэрэмжит Спортын бага наадамд спортын 8 төрлөөр нийт 64 тамирчин оролцож, шатарын төрөлд алтан медаль хүртэж, багийн дүнгээр 11 дүгээр байр эзэлсэн.



Сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийг 2019 оны 04 сарын 29-ний өдөр 5 үе шаттайгаар зохион байгуулж мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний үүргэвчний бэлэн байдлыг шалгаж, команд штабын дадлага, сургуулийг зохион байгууллаа. Мөн хээрийн хүн эмнэлэг, мал эмнэлэг дэлгэн 2 цагийн байдал дээр ажиллаж сайн дүгнэгдсэн.



Хаврын цэрэг татлагын ажлыг 2019 оны 05 сарын 07-ны өдөр зохион байгуулж, 64,6%-ийн гүйцэтгэлтэй хамрагдсан байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Хууль зүйн орон тооны бус албаны 2019 онд зохион байгуулах эрх зүйн албан бус сургалтын төлөвлөгөөний дагуу 2019 оны 05-р сарын 23-ны өдөр сумын төрийн албан хаагчдад “Харилцаа хандлага”, “Багаар ажиллах чадвар” сэдэвт сургалтуудыг илтгэгч Гандуламтай хамтран зохион байгуулж 70 гаруй албан хаагч хамрагдлаа.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

Орон нутгийн орлогын төлөвлөгөө эхний 4 сарын байдлаар 18 879,1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 22 475,1 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөө 3 596,0 мянган төгрөг буюу 19 хувиар давж биелэсэн байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

Сурагчдыг сонирхон судлах, шинжлэн судлах арга барил эзэмшүүлж арга зүйд сургах зорилгоор 12 судлагдахуунаар сургуулийн судалгаат хичээлийн уралдааныг багш нарын дунд зохион байгуулж, Шилдэг хэрэглэгдэхүүнтэй хичээлээр: Орос хэлний багш С.Эрдэнэчимэгийн “Мы изучаем русский язык”, Шилдэг үр өгөөжтэй хичээлээр: Технологийн багш С.Батхишигийн “Хуудсан материал ашиглаж бүтээл хийх”, Шилдэг арга зүйтэй хичээлээр: Англи хэлний хэлний багш Б.Буянхишигийн “Дэлхийгээ хайрлая” хичээлүүд шалгарлаа. Мөн багуудаас дундаж оноогоор: Биеийн тамирын багш Д Нарантуяа ахлагчтай “9 эрдэнэ” багийн хамт олон “Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч” багаар өргөмжлөгдлөө.

БСШУСЯ, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн дөрөвдүгээр шатны шалгаруулалтанд 16 төслөөс 5 сайн төсөл шалгарч, манай сургуулийн - “Хүүхэд хөгжлийн өргөө”- 26.328.500 төгрөгийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдлээ.

1 ангийн 3 бүлгийн 120 орчим суралцагчид “Эрдмийн баяр” уншиж, бичиж сурсны баяраа эцэг эх болон сургуулийн захиргаанд тайлагналаа.

9 дүгээр ангийн 2 бүлгийн 54 суралцагч суурь боловсрол эзэмших явцдаа сурсан мэдсэнээ эцэг эх, сургуулийн захиргаанд тайлагналаа.

Улаанбаатар хотын ардын авьяастан Хандсүрэнтэй хамтран 1-6 дугаар ангийн 480 суралцагчид умарзай, 5 суралцагчид уртын дуу, 6 суралцагчид хүүхдийн дууг зааж сургалаа.

5 дугаар сарын 03-нд хүүхдийг хичээлийн бус цагаар хөгжүүлэх 29 дугуйлангийн 857 суралцагч, 12 оролцооны бүлгийн 353 суралцагчид тайлан урлаг спортын тоглолт, бүтээлийн үзэсгэлэн, тайлант самбар, зэргийг тавьж хүмүүжлийн ажлын үйл ажиллагааг хаалаа.

3-Р ЦЭЦЭРЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын “Цөм” хөтөлбөрийн хүрээнд бага бүлэгт “Нар”, дунд бүлэгт “5 хошуу мал”, ахлах бэлтгэл бүлэгт цэцэрлэг минь баяртай сэдвээр үйл ажиллагаа явагдаж байна. Ахлах бэлтгэл бүлгийн хүүхдүүд намар хураасан цэцгийн үрээр үрсэлгээ хийх туршилт хийж байна.



Бага бүлгийн 53 хүүхдүүд “5 хошуу мал” сэдвийн хүрээнд малчны хотонд аялал хийсэн. Мөн бага бүлгийн эцэг эхчүүдийн дунд хөгжилтэй буухиа, уулын оргил булаацалдах, олс таталтын тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд цэцэрлэгийн нэгдсэн тайланг 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 150 хүүхдэд “Тусгаар тогтнол” шүлэг, 100 хүүхдэд хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөх, 20 хүүхдэд магтаал, 90 хүүхэд монгол үндэстний тойрон бүжиг, 30 хүүхдийн гимнастикийн үзүүлэх тоглолтуудыг эцэг эхдээ тайлагналаа.



Хүүхдийн хөгжмийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор 2 цохилуурт хөгжим, 3 бөмбөрөөр нэмэгдүүлсэн.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

Эрүүл мэндийн төвд 28 өвчтөн хэвтэж үүнээс 10-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.

Амбулаторийн үзлэг – 483

Урьдчилан сэргийлэх- 221

Дуудлага-145

Хөдөөгийн багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг 2019 оны 05 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулж 18 өрхийн 42 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 7 төрлийн шинжилгээнд хамруулан ажилласан.



Улаан бурхан, улаанууд өвчний вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж 10-18 насны 446 хүүхэд хамрагдахаас 469 хүүхдийг хамруулж 102 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд сумын 65-аас дээш настай 24 иргэн, 15-аас дээш настай 57 хүүхдийг элэгний В, С вирус болон бэлгийн замын халдварт өвчний шинжилгээнд хамруулж шинээр илэрсэн бэлгийн замын халдварт өвчний 8 дохиолдолыг аймгийн нэгдсэн эмнэлэгт баталгаажуулах шинэжилгээнд хүргүүлээд байна.

СОЁЛЫН ТӨВ

“Малчид дуулж байна” уралдааныг 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр малчин иргэдийн дунд зохион байгуулж 15 малчин оролцож эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа. Үүнд:

1-р байранд малчин Алтанчимэг

2-р байранд В. Оюундэлгэр

3-р байранд Ч. Байгальмаа нар тус тус шалгарсан байна.



Сумын соёлын төвтэй хамтран “Угийн бичиг” хөтлөлтийн сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 97 иргэнийг хамруулсан байна.



Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан Соёлын биет бус өв тээгчдийн анхдугаар зөвлөгөөнд сумын биет бус өвийг тээгч 40 иргэн, өвлөн суралцагч 39 сурагч оролцлоо. Дээрх зөвлөгөөний үеэр МУТАА цол тэмдэгээр Ц.Даваасүрэн шагнагдаж, 2-р багийн Засаг дарга С.Отгонбаатарын урласан арьс ширэн эдлэл 3-р байр эзэлсэн байна.



2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Хаврын найраг” шүлгийн уралдааныг зохион байгуулж, 13 иргэн оролцсоноос 2 төрлөөр 6 иргэнийг шалгарууллаа.



Говьсүмбэр аймагт зохин байгуулагдсан Яргуй-2019 наадамд “Шивээн ганхаа” хамтлаг бүжгийн төрлөөр оролцож “Шивээн ганхаа”-1, 2, 3 хамтлаг тус бүр алтан медаль хүртэж, гоцлол бүжгээр 1 алт, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн байна.

НИЙГМИЙН БОДЛОГО

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 2019 оны 05 сарын 08-ны өдөр “Гэр бүлийн аз жаргал” өдөрлөгийг зохион байгуулж 243 иргэнийг хамрууллаа. Уг арга хэмжээний “Дүэт” дууны уралдаанд:

- 1-р байрыг О. Алтанхүү, О. Сувданцэцэг
- 2-р байрыг Цолмон, Ж. Оюунгэрэл
- 3-р байрыг Ш. Бат-Амгалан, Ж. Наранцацрал нар тус тус шалгарлаа.



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Нийгмийн халамжийн тухай хуулийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 1-р багийн ахмад настан Ц.Урансайхан, Ж.Пүрэвсүрэн нарын 800000 төгрөгийн “Эрүүл амьдрал” төсөл, Ж.Хаянхярваа, И.Сандагдорж нарын 1500000 төгрөгийн “Блок үйлдвэрлэл” төслүүд дэмжигдэж гэрээ байгуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан ажилгүйдлыг бууруулах, хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг танилцуулах өдөрлөгийг 2019 оны 4-р сарын 03-ний өдөр сумын Соёлын төвд зохион байгуулан 80 иргэн хамрагдсан. Хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан иргэдэд хүргэж ажилласан. Хөтөлбөрүүдийн хүрээнд 14 төсөл хүлээн авч амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэж дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдахаар – 7 иргэний төсөл
- Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар – 1 иргэний төсөл
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдахаар – 4 өрхийн төсөл
- “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдахаар -2 ахмадын төсөл

Шивээговь суманд “Очирт тулга” ХХК, “Тунгалаг аялгуу” ХХК нар 2019 оны 5-р сарын 10-ны өдөр иргэдэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээлэл хийж, хөнгөлөлт, тусламжийг үзүүлсэн.

- Очирт тулга ХХК- 22 ахмад настанд 1830000 төгрөгийн гар таяг, нурууны даавуун бүс, тэргэнцэр, хөтөвч зэрэг тусгай хэрэгслийг олгосон.
- Очирт тулга ХХК- 7 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 725000 төгрөгийн тохой таяг, нурууны даавуун бүс, хөтөвч зэрэг тусгай хэрэгслийг олгосон.
- Тунгалаг аялгуу ХХК – 3 ахмад настанд 1050000 төгрөгийн сонсголын аппаратыг сонсголын давтамжийн дагуу хийж өгсөн.

2019 оны 5-р сарын 13, 14-ний өдрүүдэд “Алсын оч оптек” ХХК –аас 83 ахмад настанд 1245000 төгрөгийн харааны шил, 2 ахмад настанд 200000

төгрөгийн контактны линз, 14 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 210000 төгрөгийн харааны шил тааруулж хийж өгсөн.

2019 оны 5-р сарын 17-ны өдөр Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 16 өрхөд хүнсний талон олгож, 1160000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан олгосон

2019 оны 5-р сарын 15-аас эхлэн халамжийн сангийн тэтгэвэр, асаргааны болон жирэмсэн, цалинтай ээжийн тэтгэмжийг арилжааны ХААН, Төрийн банкаар дамжуулан олгосон.

- ❖ Тэтгэвэр - 54 иргэнд 9203100 төгрөг
- ❖ Асаргааны болон АДМТэтгэмж – 66 иргэнд 5907100 төгрөг
- ❖ Жирэмсэн эхийн тэтгэмж – 31 эхэд 1240000 төгрөг
- ❖ Цалинтай ээжийн тэтгэмж – 162 эхэд 8098390 төгрөг

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 43 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 11 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

5 дугаар сард газраа анх удаа өмчилж авч байгаа 8 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна.

Иргэдээс 5 дугаар сард 34 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн. Мөн 3 сард суманд орон нутгийн шилжүүлэггүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг байгууллага бүрээр гаргаж сумын Засаг даргын албан тоотоор хүргүүлсэний үр дүнд ШОХК-иас 8, ЭМТ-1, Сургууль 3 нийт 12 ажилтан, албан хаагч шилжүүлэгээ хийлгэж, бүртгүүлээд байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2019 ОНЫ 05 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	14				14	7	7
Төрсөн эх	2	14				14		14
Бүртгүүлсэн гэр бүл	3	8				8	8	8

Нас баралт	4	5				5	3	2
Цуцалсан гэр бүл	5	-				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	36				36	19	17
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

2019.05.24.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2019 оны 05-р сар						Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд				
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо			
1	Гэрлэлтийн бүртгэл	2500	1	2500					
2	Нийслэлээс шилжин ирсэн	5000	6	30000	1000	6	6000		
3	Өөр аймгаас шилжин ирсэн	3000	2	6000	1000	2	2000		
4	Сүмбэрээс шилин ирсэн	1500	1	1500	1000	1	1000		
Дүн		40000			9000				
д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар	
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо			
5	Иргэний үнэмлэх	15000	15	225000	3300	15	49500		

Дүн	225000	49500	
Нийлбэр дүн	265000	58500	
Нийт орлогын дүн	323500		

БАЙГАЛЬ ОРЧИН

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг 5 дугаар сарын 14,15-ны өдөр зохион байгуулж 16 аж ахуйн нэгж, байгууллага сумын төвийн цэцэрлэг хүрээлэн болон өөрийн эзэмшлийн талбайд 5 төрлийн 650 ширхэг модыг шинээр тарьсан.



Сумын “Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Байгаль орчноо хамгаалъя” аяныг 200000 төгрөгийн төсөвтэйгээр зохион байгуулж Хаялга нуур, Нэрт, Бэхтийн булгийн эхийн 24м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн, Нэртийн булаг болон төв хогийн цэгийн нурсан хашааг сэргээн засварласан.



Эргүүл шалгалтын хуваарийн дагуу 05 дугаар сарын 01-ны өдөр Шивээговь сумын 2-р багийн нутаг болох шоовойн говь, тогоо булаг, хавхагт, замын шовх, зүйтийн тал 8-н шороот гэсэн газруудаар нийт 125 км явж 7-н малчин өрхийн 18 иргэнд хээрийн түймэр, хууль бус ан агнуур, байгалийн өнгөт чулуу түүх байдлыг

таслан зогсоох зорилгоор эргүүл шалгалт мэдээ сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажилласан. Эргүүл шалгалтаар Страто ХХК-н Өмнөговь аймгаас нүүрс тээвэрлэхдээ Шивээговь сумын 2-р багийн нутаг болох Шоовойн говь, хар амны газар болон бэлчээрийг эвдсэн зөрчил илэрсэн.

ХӨДӨӨ АЖ АХУЙ, МАЛ ЭМНЭЛЭГИЙН ТАСАГ

Мал төллөлт 2019 оны 05 сарын 15 –ны өдрийн байдлаар 17578 мал төллөсөнөөс ингэ-17, гүү-392, үнээ-422, эм хонь-8248, эм ямаа- 8499 төллөж мал төллөлт 82% -тай, төл бойжилт-99,6%-тай байна. Төлийн хорогдол хурга-40, ишиг-30 бүгд-70, том малын зүй бус хорогдол-72, адуу-2, үхэр-2, хонь-23, ямаа-45 байна.

Хаврын вакцинжуулалтын ажил эхэлж халдварт шөвөг яр, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 4190 толгой мал хамрагдсан.

ХХААГ-тай хамтран газар тариалан эрхлэгчдэд сургалт зохион байгуулж 16 иргэнийг хамруулан зөвлөгөө зааварчилгаа өгч сонгино, хүрэн манжин, лууван, хүлэмжийн помидор зэрэг хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй олгосон.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Мэдээллийн хэрэгсэл худалдан авах ажлын шууд худалдан авалтыг “Их цэст хөгжил” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Сумын төв талбайн тохижилт, усан оргилуур байгуулах ажлын зураг төсвийн ажлыг “Би Ти Эл” ХХК-тай 3 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

Үүрдэг хогийн савны тоог нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж сумын 2-р багийн иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

С.ЯГАНЦЭЦЭГ